



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Г Даатгалын байгууллагад аудит хийх эрх олгох тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 33.2.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20.2.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 3.8.8 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Энэ тогтоолын хавсралтад нэр дурьдсан 12 аудитын компанид даатгалын байгууллагад аудит хийх эрхийг тус тус 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Даатгалын байгууллагад аудит хийх эрхийн гэрчилгээ хүчинтэй байгаа аудитын компаниудын гэрчилгээг Хорооны 2010 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 400 дугаар тогтоолоор орсон өөрчлөлтийн дагуу шинэчлэн олгосугай.

3. Компанийн өөрчлөлт, аудиторуудын шилжилт хөдөлгөөний талаар тухай бүр Хороонд мэдээлж байхыг эрх авсан аудитын компаниудад үүрэг болгосугай.

4. Даатгалын байгууллагын санхүүгийн тайланд аудит хийх эрх авсан аудитын компаниудын шилжилт хөдөлгөөн болон бусад өөрчлөлтийн талаарх мэдээллийг жилд нэг удаа Хороонд танилцуулж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Эрсдэлийн үнэлгээ, судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний газар/И.Цэрэн-Онолт/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГАД АУДИТ ХИЙХ ЭРХ АВСАН
АУДИТЫН КОМПАНИЙН НЭРС

№	Аудитын компанийн нэрс	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар	Тусгай зөвшөөрлийн дугаар
1	“Далайван Аудит” ХХК	2018365	9018001059	001-1993
2	“Лайэн Аудит” ХХК	2201456	9018001085	026-2010
3	“ПрайсуотерхаусКуперс Аудит” ХХК	2346452	9018001065	015-2010
4	“Ситико Аудит” ХХК	2112914	9011012054	006-1996
5	“Энич Аудит” ХХК	2811391	9018001011	039-2007
6	“Эс Жи Эм Ди Аудит” ХХК	5050286	9018001042	078-2009
7	“Си Эс Ай Аудит” ХХК	5303001	9018001044	081-2009
8	“Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК	2665247	9019015029	045-2002
9	“Найдвар-Од Аудит” ХХК	4383699	2011014052	061-2011
10	“Юдентакс тин Аудит” ХХК	5109922	9018001057	099-2011
11	“Фискал Аудит” ХХК	5384567	9018001055	093-2011
12	“Санхүүч Аудит” ХХК	5213657	9018001019	063-2008

----ooOoo----